



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/694

Мөрөн сум

Газар үнэгүй өмчлөх эрхийг
дуусгавар болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 31.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Даваажав овогтой Содмандах /АЮ89111562/ нь өөрийн хүсэлтээр газар өмчлөх эрхээсээ татгалзаж байгаа тул аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/564 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь дугаар заалтад заасан газраас 1983м² газрыг, Иргэн Мөнхсайхан овогтой Лхагвасүрэн /РЭ88010611/ нь өөрийн хүсэлтээр газар өмчлөх эрхээсээ татгалзаж байгаа тул аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/564 дугаар захирамжийн хавсралтын 4 дэх дугаар заалтад заасан газраас 1181м² газрыг тус тус хүчингүй болгож Монгол улсын иргэнд нэг удаа газар үнэгүй өмчлөх эрхийг дуусгавар болгосугай.

2. Даваажав овогтой Содмандах /АЮ89111562/ Аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/462 дугаар захирамжийн хавсралтын 4 дахь дугаар заалтад заасан газраас 1983м² газрыг, Иргэн Мөнхсайхан овогтой Лхагвасүрэн /РЭ88010611/ нь Аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/462 дугаар захирамжийн хавсралтын 4 дэх дугаар заалтад заасан газраас 1181м² газрыг тус тус заалтыг хүчин төгөлдөр хэвээр үлдээсүгэй.

3. Хувийн хэргийн бүрдүүлэлтийг ханган, өмчилсөн газрыг улсын бүртгэлийг өөрчлөн бүртгэж мэдээллийн санд өөрчлөлтийг тусган захиргааны актыг оролцогчдод мэдэгдэхийг Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т эрхийн баталгаанд өөрчлөлт хийхийг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус даалгасугай.

4. Аймгийн Засаг даргын энэхүү шийдвэрийг оролцогчид эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Газар эзэмшигчийн үүргийн биелэлтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Мөрөн сумын Засаг дарга (Х.Тайванбаяр)-д даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Гандэлгэр)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ТӨМӨРБААТАР



Захирамж2024

6712012166